



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн  
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/11/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



## Агуулга

<u>1.Төрийн аудитын санал, дүгнэлт</u> .....	3
<u>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.Аудитын тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.1. Ерөнхий зүйл</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.4. Материаллаг байдал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.7. Шилэн дансны мэдээлэл</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.9. Аудитын илрүүлэлт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4. Менежментийн захидал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>



## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 143

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯНТҮМЭН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА У.УРТНАСАН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянтүмэн сумын эрүүл мэндийн төв 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 90.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ





## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>19170475.22</u></b>	<b><u>25668626.23</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19170475.22	25668626.23
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4488049.20	4488049.21
35110	Тусгай зориулалттай материал	4417478.50	4417478.50
35130	Эм боох материал	70570.70	70570.71
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14592426.02	21090577.02
35410	Бичиг хэргийн материал	0.00	50000.00
35420	Аж ахуйн материал	10897750.90	15855600.90
35440	Түлш, шатах тослох материал	2520.12	2520.12
35460	Хүнсний материал	0.00	971200.00
35470	Бусад хангамжийн материал	3692155.00	4211256.00
35600	Мал амьтад	90000.00	90000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>219014772.21</u></b>	<b><u>216900132.23</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	219014772.21	216900132.23
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	215098772.21	212984132.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	38423580.64	38423580.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1104682.92	-2298677.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36338902.00	29736434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16514612.72	-12390180.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62874185.30	75524185.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21589648.29	-25760076.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38633120.00	33918100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16606705.16	-13226968.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	96655612.00	96655612.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2010978.64	-7597876.24
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3916000.00	3916000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3916000.00	3916000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>238185247.43</u></b>	<b><u>242568758.46</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>238185247.43</u></b>	<b><u>242568758.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	238185247.43	242568758.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114329046.64	114329046.64
51101	Өмч: - төрийн	114329046.64	114329046.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	60537802.10	64921313.13
51210	Өмнөх үеийн үр дүн	60537802.10	60537802.10
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	4383511.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63318398.69	63318398.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>238185247.43</u></b>	<b><u>242568758.45</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>463578940.29</b>	<b>412794773.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>141921040.29</b>	<b>51671988.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	133557650.29	20063025.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133557650.29	20063025.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133557650.29	20063025.00
122	<b>Тусламжийн орлого</b>	8363390.00	31608963.00
122001	Хандив тусламж /догоод/	8363390.00	31608963.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>321657900.00</b>	<b>361122785.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	307911700.00	329376000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307911700.00	329376000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3050000.00	20646785.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	400000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3050000.00	20246785.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10696200.00	11100000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10696200.00	11100000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>344487018.97</b>	<b>408411261.97</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>344487018.97</b>	<b>408411261.97</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	342488824.97	407539428.32
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210758650.45	245171299.58
210101	Үндсэн цалин	189826297.45	175516746.34
210102	Нэмэгдэл	11049742.00	43979744.96
210103	Унаа хоолны хөнгөлдөлт	0.00	3829964.80
210104	Урамшуулал	9845929.00	21844843.48
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26140272.00	32805123.61
210201	Тэтгэврийн даатгал	17559769.00	22617523.61
210202	Тэтгэмжийн даатгал	2146585.00	2369005.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1716400.00	2085031.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428866.00	520989.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4288652.00	5212575.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8698006.00	8706640.66
210301	Гэрэл, цахилгаан	3704516.00	3239920.66
210302	Тулш, халаалт	4693490.00	5166800.00
210303	Цэвэр, бохир ус	300000.00	299920.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15608111.00	17248480.00
210401	Бичиг хэрэг	1110000.00	2500000.00
210402	Тээвэр, шатахуун	11847251.00	10153280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845860.00	696800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3050000.00	1928400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1500000.00	1970000.00
2105	<b>Нормативт зардал</b>	26874723.84	54986591.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	16878723.84	40419491.99
210502	Хоол, хүнс	7996000.00	12067100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2000000.00	2500000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7401750.00	7865900.00
210601	Багаж, техник, хэргэсэл	400000.00	5540900.00
210604	Урсгал засвар	7001750.00	2325000.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	1000000.00	2556000.00
210702	Догоод албан томиллолт	1000000.00	2556000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21072147.00	18619652.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20824147.00	18026954.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	90000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	400000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2000.00	60000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	34200.00
210807	Газрын төлбөр	0.00	8498.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24935164.68	19579739.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6126400.00	3915100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18808764.68	15664639.98
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1998194.00	871833.65
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1998194.00	293359.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1998194.00	293359.34
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	578474.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	578474.31
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>119091921.32</b>	<b>4383511.03</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>119091921.32</b>	<b>4383511.03</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>330021290.00</b>	<b>384880515.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8363390.00</b>	<b>23757730.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	8363390.00	23757730.00
122001	Хандив тусламж /дотоод/	8363390.00	23757730.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>321657900.00</b>	<b>361122785.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	307911700.00	329376000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307911700.00	329376000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3050000.00	20646785.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	400000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3050000.00	20246785.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10696200.00	11100000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10696200.00	11100000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>330021290.00</b>	<b>384880515.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>330021290.00</b>	<b>384880515.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>328023096.00</b>	<b>384008681.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210758650.45	245171299.58
210101	Үндсэн цалин	189862979.45	175516746.34
210102	Нэмэгдэл	11049742.00	43979744.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3829964.80
210104	Урамшуулал	9845929.00	21844843.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26140272.00	32805123.61
210201	Тэтгэврийн даатгал	17559769.00	22617523.61
210202	Тэтгэмжийн даатгал	2146585.00	2369005.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1716400.00	2085031.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428866.00	520989.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4288652.00	5212575.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал</b>	8698006.00	8706640.66
210301	Гэрэл, цахилгаан	3704516.00	3239920.66
210302	Түлш, халаалт	4693490.00	5166800.00
210303	Цэвэр, бохир ус	300000.00	299920.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15608111.00	16861980.00
210401	Бичиг хэрэг	1110000.00	2500000.00
210402	Тээвэр, шатахуун	11847251.00	10153280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845860.00	696800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305000.00	1446900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1500000.00	2065000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23470499.55	46678085.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13474499.55	31334585.00
210502	Хоол, хүнс	7996000.00	12843500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2000000.00	2500000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15149010.00	8500000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8149010.00	6300000.00
210604	Урсгал засвар	7000000.00	2200000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	1000000.00	2556000.00
210702	Дотоод албан томилолт	1000000.00	2556000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21072147.00	18619652.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20824147.00	18026954.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	90000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	400000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2000.00	60000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	34200.00
210807	Газрын төлбөр	0.00	8498.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6126400.00	4109900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6126400.00	4109900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1998194.00</b>	<b>871833.65</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1998194.00	293359.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1998194.00	293359.34
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	578474.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	578474.31



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	238,185,247.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	238,185,247.43
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	238,185,247.43
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	238,185,247.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	238,185,247.43
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	4,383,511.03	4,383,511.03
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	64,921,313.13	242,568,758.46



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	342754800.00	324973096.00	364622900.00	363361896.35
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	342754800.00	324973096.00	364622900.00	363361896.35
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	342754800.00	324973096.00	364622900.00	363361896.35
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218287200.00	210758650.45	244871600.00	244871599.58
210101	Үндсэн цалин	180055100.00	189862979.45	167787600.00	175516746.34
210102	Нэмэгдэл	22970500.00	11049742.00	55454200.00	43979744.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	4851000.00	3829964.80
210104	Урамшуулал	15261600.00	9845929.00	16778800.00	21545143.48
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26816000.00	26140272.00	33057600.00	32805123.61
210201	Тэтгэврийн даатгал	18234400.00	17559769.00	23262800.00	22617523.61
210202	Тэтгэмжийн даатгал	2145600.00	2146585.00	2448700.00	2369005.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1716400.00	1716400.00	1959000.00	2085031.00
210204	Ажилгүйдлийн даатгал	429200.00	428866.00	489700.00	520989.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4290400.00	4288652.00	4897400.00	5212575.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10696200.00	8698006.00	8900000.00	8606640.66
210301	Гэрэл, цахилгаан	2839800.00	3704516.00	3533200.00	3239920.66
210302	Түлш, халаалт	7556400.00	4693490.00	5066800.00	5066800.00
210303	Цэвэр, бохир ус	300000.00	300000.00	300000.00	299920.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17188000.00	15608111.00	16446900.00	16443180.00
210401	Бичиг хэрэг	1000000.00	1110000.00	2500000.00	2500000.00
210402	Тээвэр, шатахуун	12500000.00	11847251.00	10000000.00	9999480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1188000.00	845860.00	700000.00	696800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1000000.00	305000.00	1446900.00	1446900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1500000.00	1500000.00	1800000.00	1800000.00
2105	<b>Нормативт зардал</b>	23020500.00	22420499.55	28525800.00	28525800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13420500.00	13420499.55	16025800.00	16025800.00
210502	Хоол, хүнс	7000000.00	7000000.00	10000000.00	10000000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2600000.00	2000000.00	2500000.00	2500000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17800000.00	13149010.00	8500000.00	8500000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	11300000.00	8149010.00	6300000.00	6300000.00
210604	Урсгал засвар	6500000.00	5000000.00	2200000.00	2200000.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	1000000.00	1000000.00	1800000.00	1800000.00
210702	Дотоод албан томилолт	1000000.00	1000000.00	1800000.00	1800000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21820500.00	21072147.00	19331100.00	18619652.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	21540000.00	20824147.00	18525100.00	18026954.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	180000.00	180000.00	90000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00	400000.00	400000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34500.00	2000.00	60000.00	60000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66000.00	66000.00	66000.00	34200.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00	50000.00	8498.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6126400.00	6126400.00	3189900.00	3189900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6126400.00	6126400.00	3189900.00	3189900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	360775300.00	327210086.00	437063600.00	387991460.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	336628400.00	318846696.00	412916700.00	364233730.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	336628400.00	318846696.00	388769800.00	364233730.00
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	24146900.00	8363390.00	24146900.00	23757730.00
122001	Хандив тусламж /дотоод/	24146900.00	8363390.00	24146900.00	23757730.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3050000.00	20646785.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3050000.00	20646785.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3050000.00	20646785.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	299700.00
210104	Урамшуулал		299700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	100000.00
210302	Түлш, халаалт		100000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	418800.00
210402	Тээвэр, шатахуун		153800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		265000.00
2105	Нормативт зардал	1050000.00	18152285.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54000.00	15308785.00
210502	Хоол, хүнс	996000.00	2843500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	756000.00
210702	Дотоод албан томилолт		756000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	920000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		920000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3050000.00	20646785.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3050000.00	20646785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3050000.00	20646785.00



### **3.Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг У.Уртнасан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 10-аас 2021 оны 02 дүгээр сарын 24–ний хооронд Хаан консалтинг Аудит ХХК-ын Аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлогыг оновчтой хэрэгжүүлэн, үйлчлүүлэгчдэд ээлтэй тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 408,411.3 төгрөгөөс 2 хувиар тооцон 8,168.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.



### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,383.5 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	19,170.5	25,668.6	6,498.1
Үндсэн хөрөнгө	219,014.8	216,900.1	-2,114.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>238,185.3</b>	<b>242,568.7</b>	<b>4,383.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	238,185.2	242,568.7	4,383.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>238,185.2</b>	<b>242,568.7</b>	<b>4,383.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 25,668.6 мянган төгрөг болж 6,498.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн эм, эмнэлгийн хэрэгсэл нөөцийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 216,900.1 мянган төгрөг болж 2,114.6 мянган төгрөгөөр буурсан нь ИТХ-ын тогтоолын дагуу үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө акталсан 7,380.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 242,568,7 мянган төгрөг болж 4,383.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтаас шалтгаалж байна.

Баянтүмэн сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50,784.2 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 63,924.3 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.



### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 513,369.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 513,369.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 38,718.1 мянган төгрөг бууруулж 474,650.8 мянган төгрөгөөр баталсан байна

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 364,622.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 329,376.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 24,146.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалаас, 11,100.0 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 328,797.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 10,806.6 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 23,757.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 363,361.8 мянган төгрөгийг зарцуулж 871.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 363,361.8 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь хангамж, бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 20,246.8 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 20,246.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

### **3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140, хугацаа хоцроосон 5 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 19,847.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 7,853.4 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.



Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	19,847.8	2	19,847.8	0.0	0.0	100.0
Зөвлөмж	6	7,853.4	6	7,853.4	0.0	0.0	100.0
Нийт дүн	8	27,701.2	8	27,701.2	0.0	0.0	100.0

/мянган.төгрөг/

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,881.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,010.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 59,871.2 мянган төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрснээс 53.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 59,817.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзэхэд 4,190.2 мянган төгрөгийн гүйлгээ тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн алдааг залруулсан.

Ерөнхий журналын бичилттэй тулган шалгахад бараа материалын орлогыг бүртгэхдээ тохирохгүй данс сонгосон, зарлагын 606.2 мянган төгрөгийн гүйлгээ хийхдээ зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

ЭМГ-аас 214.7 мянган төгрөгийн сүрьеэгийн эм, оношлуур, амин дэм зэрэг үнэгүй олгодог эмийн орлого аваагүй, хариуцсан эзэн байхгүй, хүлээн авсан, зарцуулсан хяналт байхгүй байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 59,871.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 53.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 59,817.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Өр төлбөр үүсээгүй бөгөөд тооцоо нийлсэн актаар тулгалт хийхэд Монголын цахилгаан холбоонд 53,9 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Харилцах дансны баримтыг шалгаж үзэхэд 2 дугаар гарын үсэггүй 21,890.3 мянган төгрөгийн 13 гүйлгээ, төрийн сангийн тамга гарын үсэг зураагүй 862.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, анхан шатны баримтгүй 1,507.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ хийгдсэн зэрэг зөрчил байна. НББ-ийн тухай хуулийн 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..." гэсэн заалттай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Худалдан авалт хийсэн бараа үйлчилгээний 103,373.6 мянган төгрөгийн зардал гарснаас 68,649.8 мянган төгрөгийн зардал и-баримттай бөгөөд 34,723.7 мянган төгрөг и-баримтгүй байна. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ..., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тус байгууллагад 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг бөгөөд түүний цалингаас ХАОАТ-ын 834.6 мянган төгрөг суутгасан байна ХХОАТ-ын тухай хуулийн 22.1,2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1,1 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Нийт 141 мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан ба 5 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр. 6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

#### 4. Менежментийн захидал

---

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

---

Огноо:	Аудитын нэр:	Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/11/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн		Мянган төгрөг



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Харилцах дансны баримтыг шалгаж үзэхэд 2 дугаар гарын үсэггүй 21,890.3 мянган төгрөгийн 13 гүйлгээ, төрийн сангийн тамга, гарын үсэг зураагүй 862.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, АШБаримтгүй 1,507.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ хийгдсэн	24,260	Албан шаардлага	ЭМТ-ын дарга, Нягтлан бодогч	У.Уртнасан Ч.Ариунзул
2	Худалдан авалт хийсэн бараа үйлчилгээний 103,373.6 мянган төгрөгийн зардал гарснаас 68,649.8 мянган төгрөгийн зардал и-баримттай бөгөөд 34,723.7 мянган төгрөг и-баримтгүй	34,722.7	Албан шаардлага	ЭМТ-ын дарга, Нягтлан бодогч	У.Уртнасан Ч.Ариунзул
3	Тус байгууллагад 1 ХБИ-ны ажилладаг бөгөөд түүний цалингаас ХАОАТ-ын 834,6 мянган төгрөг суутгасан байна.	834.6	Албан шаардлага	ЭМТ-ын дарга, Нягтлан бодогч	У.Уртнасан Ч.Ариунзул
4	Нийт 141 мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан ба 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага	ЭМТ-ын дарга, Нягтлан бодогч	У.Уртнасан Ч.Ариунзул
5	Шуудан холбооны зардлыг 53,9 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.	53.9	Төлбөрийн акт	ЭМТ-ын дарга, Нягтлан бодогч	У.Уртнасан Ч.Ариунзул
<b>ДҮН</b>		<b>59,871.2</b>			